ТӨВ АЙМАГ ДАХЬ

ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

**АУДИТЫН КОД: ТӨА-2024/121/НА-СТА-ТШЗ**

**ТӨВ АЙМГИЙН БОРНУУР СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН**

Зуунмод 2024 он


Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Ж.Бямбацогт

Утас: 70272248 Цахим хаяг: byambatsogtj@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн “Релаэнс секюритиз Аудит” ХХК


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

3. Санхүүгийн тайлангийн тодруулга.................................................................
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа ...............................................................
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин...............................................................
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.......................................................
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт .......................
4. Аудитын тайлан .................................................................................................
4.1 Ерөнхий зүйл......................................................................................................
4.2 Материаллаг байдал..........................................................................................
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт...........................................................
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.............
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт........................................
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал..................................................................
5. Аудитын илрүүлэлт .............................................................................................
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл ..................................................

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| МУЗГ | Монгол Улсын Засгийн Газар |

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.25 № 01/163

танай ______________-ны № __________________-т

ТӨВ АЙМГИЙН БОРНУУР
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА С.БУЛГАНЧИМЭГ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Борнуур сумын эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Борнуур сумын эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно. Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 зорилт 4 арга хэмжээтэй боловсруулан төлөвлөж, 90,2 хувиар хэрэгжүүлсэн байна

**Аудитын гол асуудал**

Тухайн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж

019020311

хэмжээний шийдэл бүхий ажил гүйлгээ байхгүй байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

**Бусад асуудлын хэсэг**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх болович үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ХИШИГЖАРГАЛ

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **276,525,819.73** | **180,873,482.79** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 167,775,506.28 | 66,842,166.82 |
| **311** | **Кассанд байгаа бэлэн мөнгө** | 00.00 | 00.00 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 167,775,506.28 | 66,842,166.82 |
| **3121** | **Төгрөг** | 167,775,506.28 | 66,842,166.82 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 167,775,506.28 | 66,842,166.82 |
| **33** | **АВЛАГА** | 11,617,022.00 | 21,598,897.93 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 00.00 | 18,772,420.01 |
| **335** | **Бусад авлага** | 11,617,022.00 | 2,826,477.92 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 11,617,022.00 | 2,826,477.92 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 97,133,291.45 | 92,432,418.04 |
| **351** | **Түүхий эд материал** | 51,000,512.45 | 71,195,513.04 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 25,883,846.73 | 39,326,593.27 |
| 35130 | Эм боох материал | 25,116,665.72 | 31,868,919.77 |
| **354** | **Хангамжийн материал** | 46,132,779.00 | 21,236,905.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 8,000.00 | 83,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 43,784,350.00 | 19,268,050.00 |
| 35460 | Хүнсний материал | 838,929.00 | 274,355.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 1,501,500.00 | 1,501,500.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **861,252,894.98** | **964,276,294.24** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 861,252,894.98 | 964,276,294.24 |
| **392** | **Биет хөрөнгө** | 859,449,561.64 | 962,485,183.12 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 695,720,497.30 | 775,420,497.30 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -46,715,889.60 | -47,689,137.30 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 74,600,000.00 | 65,600,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -29,678,333.47 | -33,144,333.19 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 228,398,800.53 | 259,961,343.06 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -91,473,232.83 | -111,123,042.84 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 54,268,245.78 | 80,974,476.98 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -26,662,082.07 | -28,506,176.89 |
| 39217 | Ном | 991,556.00 | 991,556.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 1,803,333.34 | 1,791,111.12 |
| 39301 | Програм хангамж | 1,045,000.00 | 825,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -641,666.66 | -433,888.88 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 1,400,000.00 | 1,400,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,137,778,714.71** | **1,145,149,777.03** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **19,123,060.00** | **251.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 19,123,060.00 | 251.00 |
| **413** | **Өглөг** | 19,123,060.00 | 251.00 |
| 41330 | Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг | 19,122,200.00 | 00.00 |
| **4136** | **Бусад өглөг** | 860.00 | 251.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,118,655,654.71** | **1,145,149,526.03** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,118,655,654.71 | 1,145,149,526.03 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 606,283,482.44 | 606,283,482.44 |
| 51101 | Өмч: - төрийн | 606,283,482.44 | 606,283,482.44 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 383,687,031.03 | 410,180,902.35 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 383,687,031.03 | 383,687,031.03 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 26,493,871.32 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 128,685,141.24 | 128,685,141.24 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,137,778,714.71** | **1,145,149,777.03** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **921,817,501.69** | **968,610,342.03** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **112,125,311.69** | **158,503,904.24** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 112,125,311.69 | 158,503,904.24 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 111,945,453.32 | 1,295,910.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 1,295,910.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 111,945,453.32 | 00.00 |
| 120009 | Бусад орлого | 179,858.37 | 00.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **809,692,190.00** | **810,106,437.79** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 250,000.00 | 00.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 250,000.00 | 00.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 36,532,800.00 | 63,488,900.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 36,532,800.00 | 63,488,900.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 772,909,390.00 | 746,617,537.79 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 772,909,390.00 | 746,617,537.79 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **744,535,986.52** | **942,116,470.71** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **744,535,986.52** | **942,116,470.71** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 743,341,675.62 | 919,930,492.63 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 362,834,106.24 | 506,996,873.76 |
| 210101 | Үндсэн цалин | 236,528,401.26 | 307,185,083.63 |
| 210102 | Нэмэгдэл | 79,931,536.06 | 164,725,626.11 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 4,694,000.00 | 4,795,000.00 |
| 210104 | Урамшуулал | 41,680,168.92 | 30,291,164.02 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 53,670,527.09 | 60,907,999.48 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 39,617,063.93 | 41,401,592.44 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,826,975.06 | 4,833,624.82 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,947,339.89 | 4,119,924.39 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 661,740.79 | 892,450.83 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,617,407.42 | 9,660,407.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 33,210,889.10 | 39,102,921.92 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,785,306.10 | 4,010,690.92 |
| 210302 | Түлш, халаалт | 30,180,583.00 | 34,792,231.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 245,000.00 | 300,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 70,239,203.94 | 81,246,900.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 6,374,000.00 | 5,757,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 43,716,010.00 | 41,801,400.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,752,993.22 | 2,080,500.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 4,145,000.00 | 3,317,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 00.00 | 3,590,000.00 |
| 210408 | Бараа материал актлалсны зардал | 14,251,200.72 | 24,701,000.00 |
| **2105** | **Норматив зардал** | 125,436,395.24 | 126,975,865.65 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 111,595,437.24 | 107,977,741.65 |
| 210502 | Хоол, хүнс | 13,840,958.00 | 18,998,124.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 19,877,340.00 | 22,255,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 8,920,940.00 | 2,322,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 10,956,400.00 | 19,932,500.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,064,000.00 | 2,214,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,064,000.00 | 2,214,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 00.00 | 1,814,163.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 00.00 | 1,209,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 00.00 | 381,675.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 00.00 | 128,144.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 00.00 | 55,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 00.00 | 40,344.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 76,009,214.01 | 78,416,768.82 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 18,942,908.00 | 12,382,589.08 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 57,066,306.01 | 66,034,179.74 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1,194,310.90 | 22,185,978.08 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 1,194,310.90 | 22,185,978.08 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 22,185,978.08 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **177,281,515.17** | **26,493,871.32** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 7,921,603.50 | 00.00 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 7,921,603.50 | 00.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | -7,921,603.50 | 00.00 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **169,359,911.67** | **26,493,871.32** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **902,596,066.57** | **779,714,499.78** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **179,858.37** | **7,502,682.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 179,858.37 | 7,502,682.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 00.00 | 7,502,682.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 7,502,682.00 |
| 120009 | Бусад орлого | 179,858.37 | 00.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **902,416,208.20** | **772,211,817.78** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 250,000.00 | 00.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 250,000.00 | 00.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 36,532,800.00 | 63,488,900.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 36,532,800.00 | 63,488,900.00 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | 92,455,200.00 | 00.00 |
| 133001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 92,455,200.00 | 00.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 773,178,208.20 | 708,722,917.78 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 773,178,208.20 | 708,722,917.78 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **686,823,639.00** | **832,860,539.24** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **686,823,639.00** | **832,860,539.24** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **685,629,328.10** | **810,674,561.16** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 363,206,397.98 | 506,996,873.76 |
| 210101 | Үндсэн цалин | 236,900,693.00 | 307,185,083.63 |
| 210102 | Нэмэгдэл | 79,931,536.06 | 164,725,626.11 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 4,694,000.00 | 4,795,000.00 |
| 210104 | Урамшуулал | 41,680,168.92 | 30,291,164.02 |

| | | | |
|---|---|---|---|
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 52,917,833.92 | 61,186,816.48 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 39,016,987.01 | 41,103,538.74 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,826,975.06 | 5,336,905.61 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,947,339.89 | 4,119,924.39 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 612,598.08 | 966,040.74 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,513,933.88 | 9,660,407.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 33,210,889.10 | 39,102,921.92 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,785,306.10 | 4,010,690.92 |
| 210302 | Түлш, халаалт | 30,180,583.00 | 34,792,231.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 245,000.00 | 300,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 57,060,503.22 | 56,496,200.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 6,391,500.00 | 5,757,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 43,716,010.00 | 41,591,400.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,752,993.22 | 2,080,500.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 4,525,000.00 | 3,317,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 675,000.00 | 3,750,300.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 99,370,133.88 | 109,686,186.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 82,870,383.88 | 92,286,636.00 |
| 210502 | Хоол, хүнс | 14,499,750.00 | 17,399,550.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,000,000.00 | 00.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 42,144,800.00 | 14,646,200.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 9,482,000.00 | 1,100,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 16,140,200.00 | 2,237,200.00 |
| 210604 | Урсгал засвар | 16,522,600.00 | 11,309,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,064,000.00 | 2,214,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,064,000.00 | 2,214,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 00.00 | 1,814,163.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 00.00 | 779,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 430,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 00.00 | 381,675.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 00.00 | 128,144.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 00.00 | 55,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 00.00 | 40,344.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 35,654,770.00 | 18,531,200.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 35,654,770.00 | 18,531,200.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1,194,310.90** | **22,185,978.08** |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 1,194,310.90 | 00.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,194,310.90 | 00.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 00.00 | 22,185,978.08 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 22,185,978.08 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **215,772,427.57** | **-53,146,039.46** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **53,107,000.00** | **47,787,300.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **53,107,000.00** | **47,787,300.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 53,107,000.00 | 47,787,300.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 53,107,000.00 | 47,787,300.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-53,107,000.00** | **-47,787,300.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 162,665,427.57 | -100,933,339.46 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 5,110,078.71 | 167,775,506.28 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 167,775,506.28 | 66,842,166.82 |

### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|
| C01 | 2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 606,283,482.44 | 183,121,559.88 | 789,405,042.32 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 606,283,482.44 | 183,121,559.88 | 789,405,042.32 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 123,570,396.27 | 123,570,396.27 |
| C08 | 2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 606,283,482.44 | 383,687,031.03 | 989,970,513.47 |
| D01 | 2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 606,283,482.44 | 383,687,031.03 | 989,970,513.47 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 606,283,482.44 | 383,687,031.03 | 989,970,513.47 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 26,493,871.32 | 26,493,871.32 |
| D09 | 2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 606,283,482.44 | 410,180,902.35 | 1,016,464,384.79 |

### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

| № | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 1,113,156,500.00 | 840,085,361.16 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,113,156,500.00 | 840,085,361.16 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,113,156,500.00 | 840,085,361.16 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 635,066,400.00 | 506,996,873.76 |
| 210101 | Үндсэн цалин | 387,844,400.00 | 307,185,083.63 |
| 210102 | Нэмэгдэл | 140,200,800.00 | 164,725,626.11 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 4,939,000.00 | 4,795,000.00 |
| 210104 | Урамшуулал | 102,082,200.00 | 30,291,164.02 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх ши** | 78,164,100.00 | 61,186,816.48 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 54,816,400.00 | 41,103,538.74 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,290,400.00 | 5,336,905.61 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,548,100.00 | 4,119,924.39 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,137,600.00 | 966,040.74 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 11,371,600.00 | 9,660,407.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 00.00 | 38,192,921.92 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 00.00 | 4,010,690.92 |
| 210302 | Түлш, халаалт | 00.00 | 33,882,231.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 00.00 | 300,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 61,249,100.00 | 56,496,200.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 6,499,700.00 | 5,757,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 44,999,700.00 | 41,591,400.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,999,700.00 | 2,080,500.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн ус | 2,999,700.00 | 3,317,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,750,300.00 | 3,750,300.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 117,560,400.00 | 109,686,186.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 92,534,500.00 | 92,286,636.00 |
| 210502 | Хоол, хүнс | 23,525,600.00 | 17,399,550.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,500,300.00 | 00.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 71,749,700.00 | 51,177,200.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 32,699,400.00 | 22,690,000.00 |
| 210602 | Тавилга | 00.00 | 00.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 9,000,300.00 | 2,237,200.00 |
| 210604 | Урсгал засвар | 30,050,000.00 | 26,250,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,842,200.00 | 2,214,000.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | 00.00 | 00.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,842,200.00 | 2,214,000.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 00.00 | 00.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлб** | 2,548,900.00 | 1,814,163.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчил | 898,900.00 | 779,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 430,000.00 | 430,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 400,000.00 | 381,675.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 400,000.00 | 128,144.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 70,000.00 | 55,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 50,000.00 | 40,344.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний | 300,000.00 | 00.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 143,975,700.00 | 12321000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 143,975,700.00 | 12,321,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 00.00 | 750,768,227.78 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 00.00 | 40,749,400.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 00.00 | 40,749,400.00 |
| **1340** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС С** | 00.00 | 708,722,917.78 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжи | 00.00 | 708,722,917.78 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНАА** | 00.00 | 1,295,910.00 |
| 1E+06 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 1,295,910.00 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэ** | 00.00 | 167,775,506.28 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгд** | 00.00 | 66,842,166.82 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Борнуур сумын Эрүүл мэндийн төв нь ард иргэдэд Эрүүл мэндийн байгууллагын мэргэжлийн бүх төрлийн чиглэлийн үйл ажиллагаа үзүүлдэг Эрүүл мэндийн яамны харьяа байгууллага юм.

Төв аймгийн Борнуур сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оныг "Иргэн бүрт эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг" жил болгон зарлаж, дэвшүүлсэн зорилго, зорилтын хүрээнд байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 зорилт, 4 арга хэмжээтэйгээр боловсруулан хэрэгжүүлж, төлөвлөгөөг 90,2 хувиар биелүүлж ажилласан байна.

Тус Эрүүл мэндийн төв нь 24 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь үйл ажиллагаандаа

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Эрүүл мэндийн тухай хууль,
- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль
- Төсвийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил гүйлгээ худалдан авах тухай хууль,
- Шилэн дансны тухай хууль,
- Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжууд мөн Сангийн яам болон харьяа эрүүл мэндийн яамнаас гаргасан тушаал,заавар журам шийдвэрүүдийг мөрдөж ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт *ороогүй* байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт *үр нөлөөтэй* байна.

Тус байгууллага 2023 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр Сумын Засаг даргын нэрэмжит шалгалтаар 82,6 хувьтай, Төв аймгийн Эрүүл мэндийн газраас хяналт үнэлгээ шинжилгээний шалгалтаар 88,5 хувьтай тус тус дүгнэсэн байна.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах *шаардлагагүй гэж* үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Борнуур сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурьиар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Борнуур сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.
Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 7,371.0 мянган төгрөгөөр буюу 0,6 хувиар *өссөн* байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| **Мөнгөн хөрөнгө** | 167,775.6 | 66,842.2 | -100,933.4 |
| **Авлага** | 11,617.0 | 21,598.8 | 9,981.8 |
| **Урьдчилгаа** | | | |
| **Бараа материал** | 97,133.2 | 92,432.4 | 4,700.8 |
| **Үндсэн хөрөнгө** | 861,252.9 | 964,276.3 | 103,023.4 |
| **Нийт хөрөнгө** | **1,137,778.7** | **1,145,149.7** | **7,371.0** |
| **Өр төлбөр** | 19,123.0 | | |
| **Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/** | 1,118,655.7 | 1,145,149.7 | -26,494.0 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **1,137,778.7** | **1,145,149.7** | **7,371.0** |

Дээрх хүснэгтээс харахад 2023 оны жилийн эцэст

- Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 100,933.4 мянган төгрөгөөр буурсан байна.
- Бараа материал дансны үлдэгдэл 92,432.4 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 4,700.8 мянган төгрөгөөр буурсан нь гэнэтийн осол аваараас шалтгаалан зарцуулалт өссөнтэй холбоотой байна. Улсын төсвийн хөрөнгөөр 222,593.3 мянган төгрөгийн эм, эмийн хэрэгсэл боох материал, хүнсний материал, аж ахуйн бараа материал, бичиг хэргийн материал,сэлбэг хэрэгсэл, бусад хангамжийн материал худалдан авсан. Хандиваар 35,937.7 мянган төгрөгийн эм эмийн хэрэгсэл, боох материалыг Аймгийн эрүүл мэндийн газраас, хангамжийн материалыг Бороо Гоулд ХХК-с үнэ төлбөргүй хүлээн авсан.
- Авлага дансны үлдэгдэл 21,598.8 мянган төгрөг байгаа нь өмнөх өнөөс 9,981.8 мянган төгрөгөөр өссөн нь Эрүүл мэндийн даатгалын сангаас авах авлага байна. Эрүүл мэндийн байгууллагаас 18,772.4 мянган төгрөг, хувь иргэдээс 2,826.4 мянган төгрөгийн авлагатай байна.

- Үндсэн хөрөнгө данс нь оны эцэст 964,276,.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 103,023.4 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр тавилга тоног төхөөрөмж худалдан авсан, мөн хандиваар хүлээж авсантай тус тус холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны дэлгэрэнгүй бүртгэлээс харахад:

- 47,787.3 мянган төгрөгийн тавилга, тоног төхөөрөмжийг улсын төсвийн хөрөнгөөр, 33,169.2 төгрөгийн тоног төхөөрөмжийг Эрүүл мэндийн газраас, 18,101.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил хандиваар тус тус авсан.
- 70,000.0 мянган төгрөгөөр орон нутгийн хөрөнгөөр их засвар хийж капиталжуулсан.
- Төв аймгийн Борнуур сумын ИТХ-н 2023 оны 12 сарын 18 өдрийн 9 тоот тогтоолоор тавилга эд хогшил 6,947.0 мянган төгрөг, тоног төхөөрөмж 24,141.7 мянган төгрөг, программ хангамж 220.0 мянган төгрөг, авто тээврийн хэрэгсэл 9,000.0 нийт 40,308.8 мянган төгрөгийн хөрөнгийг тус тус акталж устгасан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 947,581.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 61,288.9 мянган төгрөг нийт зарлагыг 1,008,869.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.
Төсвийн төслийн саналаас 1,008,869.9 мянган төгрөгөөр зардлыг баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 1,008,869.9 мянган төгрөгөөр баталсан байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 947,581,0 мянган төгрөгийг улсын төсвөөс, орон нутгийн төсвөөс 61,288.9 мянган төгрөгийг тус тус бүрдүүлсэн ба нийт зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр 1,008,869.9 мянган төгрөг байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 801,892.4 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 38,192.9 мянган төгрөгийн санхүүжилт олгож, нийт 840,085.3 төгрөгийг төвлөрүүлсэн байна.
Төсвийн зардлын гүйцэтгэл 840,085.3 мянган төгрөг буюу 83,2 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг нийт 168,784.6 мянган төгрөгөөр, үүнээс үндсэн цалин 80,659.3 мянган төгрөг, урамшуулал 71,791.0 мянган төгрөгөөр, байр ашиглахтай холбоотой зардлыг 23,095.9 мянган төгрөгөөр, хангамжийн бараа материалын зардлыг 4,752.9 мянган төгрөгөөр, норматив зардлыг 7,874.2 мянган төгрөгөөр, эд хогшил худалдан авах зардлыг 22,772.5 мянган төгрөгөөр, бусад зардлыг 1,362.9 мянган төгрөгөөр тус тус төлөвлөснөөс дутуу зарцуулсантай холбоотой байна Мөн нэмэгдэл цалин 24,524.8 мянган төгрөгөөр хэтэрсэн байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | 71802 Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| **81603** | Үндсэн үйл ажиллагааны зардал | 325,793.3 | 131,533.3 | 194,259.9 | 40,4% |
| **83603** | Нэмэлт дээд шатны төсвөөс хуваарилсан | 178,197.1 | 117,020.0 | 61,177.0 | 65,7% |
| **80302** | 1 иргэнд ноогдох номативт зардал | 609,166.1 | 551,139.0 | 58,027.0 | 90,5% |
| **80111** | Төрийн өмчийн барилгын тогтмол зардал | 63,488.9 | 39,102.9 | 22,185.9 | 65,1% |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Борнуур сумын Эрүүл мэндийн төв нь 2023 онд нэмэлт санхүүжилтийн дансаар гүйлгээ хийгдээгүй.

### *3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн*

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

*Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт*

/мянган төгрөгөөр/

| № | Хөтөлбөр | Хэрэгжих хугацаа | Хүрэх үр дүн | Хэрэгжилтийн явц | Зарцуулах төсөв | Зарцуулсан |
|---|---|---|---|---|---|---|
| **1** | 71602-81603 | 2023-12-31 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 40,4% | 325,793.3 | 131,533.3 |
| **2** | 71602-83603 | 2023-12-31 | Нэмэлт дээд шатны төсвөөс хуваарилсан | 65,7% | 178,197.1 | 117,020.0 |
| **3** | 71602-80302 | 2023-12-31 | 1 иргэнд ноогдох нормтивт зардал | 90,5% | 609,166.1 | 511,139.0 |
| **4** | 71602-80111 | 2023-12-31 | Төрийн өмчит барилгын тогтмол зардал | 65,1% | 63,488.9 | 39,102.9 |

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төв аймгийн Борнуур сумын Эрүүл мэндийн төв нь 2023 онд цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй байна. Аймгийн Эрүүл мэндийн газраас тендер шалгаруулсан газруудаас эм, эмийн хэрэгсэл боох материалыг нийлүүлдэг. Хүнсний бараа материалыг тендерт шалгарсан Өгөөмөр ХХК-с худалдан авалт хийдэг. Шатахууныг Дархан НИК ХХК-аас гэрээгээр авдаг байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Борнуур сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах анхан шатны бүртгэлийг бүрэн хөтөлж хэвших болон шилэн данстай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Релаэнс секюритиз аудит ХХК -ийн ахлах аудитор Б.Мягмар, аудитор С.Дашдондог нар гүйцэтгэж, хяналтыг Релаэнс секюритиз аудит ХХК-ийн захирал, аудитор Ж.Цэцэгмаа, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Бямбацогт, аудитын менежер О.Амаржаргал, дарга, Тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Борнуур сумын Эрүүл мэндийн төв нь 2023 оны оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Релаэнс секюритиз аудит ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 15 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн, нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Борнуур сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 455,000.0 мянган төгрөгөөс 2,0 хувиар буюу 9,100.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 7,280.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох *шаардлагагүй* гэж үзлээ.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хэмнэж ажилласны үр дүнд ажиллагсдад олгох цалин хөлстэй холбоотой орон тоог хэмнэж ажиллах, төлөвлөгдсөн бараа ажил үйлчилгээний зардлыг төлөвлөгөөт хэмжээнд нь зарцуулах буюу хэмнэх зэрэг арга хэмжээ авч ажилласан байна.

Төв аймгийн Борнуур сумын Эрүүл мэндийн төв нь 2023 онд батлагдсан төсвийг үр бүтээлтэй хэрэгжүүлэн ажилласан байна. 2023 оны төсвийг хэмнэж үр бүтээлтэй ажиллах, тогтмол зардал болон эд хогшил худалдан авах зардлыг хэмнэх арга хэмжээ авснаар доорхи хэмнэлт гаргасан байна.Үүнд:. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл, урамшууллыг 128,069.5 мянган төгрөгөөр
- Байр ашиглахтай холбоотой болон эд хогшил худалдан авах зардлыг 23,096.0 мянган төгрөгөөр
- Хангамжийн бараа материал болон бусдаар гүйцэтгэх ажил үйлчилгээний зардлыг 4,753.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэж ажилласан байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны хөтлөлтийг шалгахад 2023 онд тус эрүүл мэндийн төв нь 159 мэдээллийг шилэн дансанд байршуулахаас 154 мэдээллийг байршуулж 5 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан. Энэ нь шилэн дансны тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.1.1-д “Мэдээлэл үнэн зөв бодитой иж бүрэн байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд тогтмол шуурхай мэдээлдэг байх”, 6.4.4-д ”Таван саяас дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа ажил гүйлгээ”, МУЗГ-ын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 7 дугаар зүйлийн 7.5.3-д “өөрийн хянах цэсийн мэдээллийг байнга хянах” заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны хууль, журмын заалтуудыг хэрэгжүүлэн ажиллах зөвлөмж өгөв.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Борнуур сумын Эрүүл мэндийн газрын эхний 2023 оны 9 дүгээр сарын 30-наар тасалбар болгосон санхүүгийн тайланд хийгдсэн Завсрын аудитын явцад хөрөнгийн болон зардлын данстай холбоотой 199,147.4 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгөгдсөн. Биелэлтийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад 1 зөвлөмж нь хэрэгжээгүй тул аудитын тайланд тусгаж зөрчлөөр оруулсан болно.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| **Акт** | | | | | |
| **Албан шаардлага** | 2 | 63,356.1 | 1 | 63,356.1 | 100 |
| **Зөвлөмж** | | | | | |
| **Нийт дүн** | **2** | 63,356.1 | | **63,356.1** | **100** |

**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татах асуудал байхгүй.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 182.826.4 мянган төгрөгийн зөрчил илэрснээс аудитын явцад 180,000.0 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 2,826.4 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоов.

Үндсэн хөрөнгийн хувийн хэрэгт тус хөрөнгийн үнийг 180,000.0 мянган төгрөгөөр зөрүүтэй бичсэн. Энэ нь Зам, тээвэр, барилга хот байгуулалтын сайдын 2009 оны 3 дугаар сарын 18-ны 71 тоот тушаалаар батлагдсан журмын 1-р заалт Барилга байгууламжийн ашиглалт, өргөтгөл шинэчлэл, их засварын хувийн хэрэг хөтлөх журмыг дагаж мөрдөөгүй, санхүүгийн тайлангийн “Иж бүрэн байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

**5.1 Төлбөрийн акт**

1. Авлагын данстай холбоотой асуудал

*Илрүүлэлт:*

Байгууллага болон хувь хүнээс авах 2,826.4 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй зөрчил илэрсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна. .

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.7-д “авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

Дээрх төлбөрийн актын биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 5 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Үндсэн хөрөнгийн хувийн хэрэгт тус хөрөнгийн үнийг зөрүүтэй бичсэн | 1 | 180,000.0 | | | | | 1 | 180,000.0 | | | | |
| | | | | | | | | | | | | |
| Дүн | 1 | 180,000.0 | | | | | 1 | 180,000.0 | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Хувь хүн байгууллагаас авах авлагын тооцоог барагдуулаагүй | 1 | 2,826.4 | 1 | 2,826.4 | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |
| Дүн | 1 | 2,826.4 | 1 | 2,826.4 | | | | | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Шилэн дансанд байршуулах 5 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан | 1 | 21,300.0 | | | | | 1 | 21,300.0 |
| | | | | | | | | |
| Дүн | 1 | 21,300.0 | | | | | 1 | 21,300.0 |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Нийт дүн | | | | | | | | |

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn